



2024 оны 10 дугаар сарын 1

ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Стандарт

(хувилбар 1.1)

ТОГТВОРТОЙ НООС НООЛУУРЫН ЭВСЭЛ



Лавлах материалууд

ТННЭ-ийн хөтөлбөрийн баримт бичгүүд

- [ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандарт](#)
- [ТННЭ-ийн Цэвэр Ноолуур Боловсруулах Стандарт](#)
- [Брэндийн таниулах удирдамж](#)
- [ТННЭ-ийн Үнэлгээ, баталгаажуулалтын журам](#)
- [ТННЭ-ийн Нэр томъёоны тайлбар толь](#)
- [ТННЭ-ийн Стандарт Тохируулах Журам](#)

ТННЭ-ийн вэб холбоосууд

- [Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл - Тохирлын Үнэлгээний Байгууллагууд](#)
- [Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл - Гүйлгээний бүртгэл, Мөшгөлтийн цахим систем](#)

Хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацаа

2025 оны 3 дугаар сарын 1-ний байдлаар ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандарт (хувилбар 1.1) болон түүний өмнөх хувилбаруудын аль нэгээр баталгаажуулалт хийлгээгүй бөгөөд 'SFA Certified' бүтээгдэхүүний худалдаанд оролцох хүсэлтэй бүх оролцогч этгээдүүд нь 2025 оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандарт (хувилбар 1.1)-ийн дагуу (эсвэл Хүснэгт 1-т тусгасан аливаа хүлээн зөвшөөрөгдсөн дүйцэх стандартын дагуу) баталгаажсан байх шаардлагатай.

2025 оны 3 дугаар сарын 1-ний байдлаар ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандарт (хувилбар 1.0) болон түүний өмнөх хувилбаруудын аль нэгээр баталгаажсан бөгөөд 'SFA Certified' бүтээгдэхүүний худалдаанд үргэлжлүүлэн оролцох хүсэлтэй бүх оролцогч этгээдүүд нь тухайн хүчин төгөлдөр байгаа Хамрах хүрээний гэрчилгээний хугацаа дуусахаас өмнө ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандарт (хувилбар 1.1)-ын дагуу баталгаажсан байх ёстой.

Бүх оролцогч этгээдүүд нь энэхүү баримт бичиг нийтлэгдсэн өдрөөс эхлэн баталгаажуулалтанд хамрагдах боломжтой.

ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандарт (хувилбар 1.1) нь өмнөх бүх хувилбаруудын хүчин төгөлдөр хэрэгжих хугацааг дуусгавар болгож байна. Энэ нь оролцогч этгээдүүд нь 2025 оны 3 дугаар сарын 1 хүртэл ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны удирдамж (хувилбар 3.1)-ын дагуу баталгаажуулалтад хамрагдаж болно гэсэн үг юм.

Хүчинтэй хугацааны өөрчлөлтөд хамаарахгүй цор ганц заалт нь ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандарт (хувилбар 1.0 болон 1.1)-ын 1.1.8 дугаар шалгуур байна. Тус шалгуурт 2024 оны 11 дүгээр сарын 1-нээс эхлэн 'SFA Certified' ноолуурыг угаах болон/эсвэл самнаж буй бүх үйлдвэрүүд, энэ стандартын шаардлагын дагуу баталгаажуулалтанд хамрагдах буюу одоо байгаа баталгаажуулалтаа хадгалахыг хүсэж байгаа тохиолдолд, ТННЭ-ийн Цэвэр Ноолуур Боловсруулах Стандартын хамгийн сүүлийн хувилбар эсвэл хүчин төгөлдөр байгаа түүний өмнөх хувилбаруудын дагуу баталгаажсан байх ёстой гэж тусгасан. Тус шаардлага нь 2024 оны 11 дүгээр сарын 1-нээс эхлэн 'SFA Certified' ноолуурыг угаах болон/эсвэл самнаж буй, ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандарт (хувилбар 1.1) болон түүний өмнөх хувилбаруудын гэрчилгээ эзэмшигч бүх үйлдвэрүүдэд хамаарна. Иймээс 2024 оны 11 дүгээр сарын 1-нээс хойш шинээр олгогдох бүх гэрчилгээ нь тухайн оролцогч этгээд аль хувилбарын дагуу баталгаажсан байхаас үл хамааран, ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандарт (хувилбар 1.1)-ийн 1.1.8 дугаар шалгуурт нийцсэн байх шаардлагатай гэсэн үг юм.

Энэхүү баримт бичигт шаардлага, зөвлөмж, зөвшөөрөл, боломж болон чадавхийг илэрхийлэхэд дараах үг хэллэгийг ашигласан болно:

- “...на, ...нэ, ...но, ...нө” гэж төгссөн бол шаардлага гэж;
- “зохино” гэж төгссөн бол зөвлөмж гэж;
- “боломжтой” гэж төгссөн бол зөвшөөрч байгаа гэж;
- “болно” гэж төгссөн бол боломж болон чадавх гэсэн утгыг тус тус заана

 Зааварчилгааг илэрхийлнэ. Энэ нь өөрөө норматив буюу стандартын шаардлагыг заахгүй боловч норматив шаардлагуудыг давтах, бататгах эсвэл тодруулж болно.

Орчуулагчийн тайлбар: Энэхүү стандартад хэрэглэгдэж буй “оролцогч этгээд” болон “нэгж” гэх нэр томъёог дараах утгаар ойлгоно. Эдгээр болоод бусад нэр томъёоны дэлгэрэнгүйг ТННЭ-ийн Нэр томъёоны тайлбар толиноос харна уу.

Төрөл	Тайлбар
Оролцогч этгээд (Entity)	Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд оролцож буй малчдын байгууллага, арилжаа эрхлэгч, боловсруулах үйлдвэр, үйлдвэрлэгч, жижиглэн худалдаа эрхлэгчдийг нийтэд нь хэлнэ.
Нэгж (Site)	Ерөнхий утгаараа хэрэглэгддэг бөгөөд дараах хоёр төрлийн нэгжүүдийг хэлнэ.
Нэгж (малчин өрх)	Бэлтгэн нийлүүлэгч малчдын байгууллагад хамаарах шалгуурын хүрээнд ашиглагдана.
Нэгж (салбар)	Боловсруулах үйлдвэр, арилжаа эрхлэгч, бренд, жижиглэн худалдаанд хамаарах шалгуурын хүрээнд ашиглагдана.

Баримт бичгийн шинэчлэл

Энэхүү стандарт нь ТННЭ-ийн бүтээл, санаачилга болно. Тус стандартын загвар болон хэрэгжүүлэлт, эсвэл ТННЭ-ийн хэрэгжүүлдэг аливаа хөтөлбөр, стандартын талаарх санал, сэтгэгдлийг [ТННЭ-ийн албан ёсны нээлттэй хэлэлцүүлгийн портал](#)-аар дамжуулан илгээнэ үү. Энэхүү баримт бичгийг өмнөх үндсэн хувилбар нь хэвлэгдсэнээс хойш 3 жилийн дотор хянаж, дүгнэх ба энэ хугацаанд илгээсэн бүх санал, асуудлыг анхааралтай авч үзэх болно.

Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Хувилбар	Агуулга	Шинэчлэл	Огноо
1.0	ТННЭ-ийн Мөшгөлтийн Тогтолцооны Удирдамж (хувилбар 3.1)-ийн шинэчлэл	ТННЭ-ийн Мөшгөлтийн Тогтолцооны Стандарт (хувилбар 1.0)-ын Өөрчлөлтийн Тойм -ыг үзнэ үү.	01/04/2024
1.1	ТННЭ-ийн Мөшгөлтийн Тогтолцооны Стандарт (хувилбар 1.0)-ын шинэчлэл	Ерөнхий мэдэгдлүүдэд ТННЭ-ийн лого хэрхэн ашиглагдах тухай болон худалдан авагч нь ТННЭ-ийн Мөшгөлтийн Тогтолцооны Стандартаар баталгаажсан тохиолдолд гүйлгээний бүртгэлд зөвхөн худалдан авагчийн хамрах хүрээний гэрчилгээний дугаарыг оруулах шаардлагатай тухай тодруулга. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандарт, хувилбар 1.0 (2024 оны 12 сарын 1-ны өдөр нийтлэгдэхээр төлөвлөгдсөн)-н Өөрчлөлтийн тоймоос харна уу.	01/10/2024



АГУУЛГА.....	5
1. ХАМРАХ ХҮРЭЭ.....	6
2. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ШААРДЛАГА	8
2.1. Оролцогч этгээдийн бүтэц.....	8
2.2. Оролцогч этгээдийн эрх зүйн статус	8
2.3. Баримтжуулсан журам	8
2.4. Нөөц болон сургалт	9
2.5. Менежментийн системийн хяналт.....	9
2.6. Бүртгэл хөтлөлт	9
2.7. Тайлан ба ил тод байдал.....	12
2.8. Боловсруулалт, хадгалалт ба тээвэрлэлт	12
2.9. Гүйлгээ.....	13
2.10. Тоо хэмжээний тохируулга	14
2.11. Мэдэгдэл	17

1. ХАМРАХ ХҮРЭЭ



1.1 Хамрах хүрээний шаардлага

Энэ хэсэгт 'SFA Certified' бүтээгдэхүүнийг худалдаалахын тулд батаалгаажилтад хамрагдсан байх шаардлагатай бүх оролцогч этгээдүүд, мөн шаардлагуудыг хэрэгжүүлэхэд хамаарах аливаа чөлөөлөлтүүдийг тусгасан болно.

- 1.1.1 Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд 'SFA Certified' бүтээгдэхүүнийг хууль ёсоор эзэмшигч бүх оролцогч этгээдүүд нь 'SFA Certified' бүтээгдэхүүнийг борлуулах, шошгожуулах болон/эсвэл боловсруулахтай холбоотой мэдэгдэл гаргахаас өмнө, ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын дагуу, ТННЭ-с зөвшөөрөл авсан, итгэмжлэгдсэн гуравдагч этгээд (өөрөөр хэлбэл, тохирлын үнэлгээний байгууллага-ТҮБ)-ээр баталгаажилтад хамрагдсан **байна**.
- ТННЭ-ийн Мөшгөлтийн Тогтолцооны Стандартын дагуу баталгаажилтад хамрагдаагүй оролцогч этгээдийн өмчлөл, эзэмшилд очсон аливаа 'SFA Certified' бүтээгдэхүүн нь цаашид 'SFA Certified' бүтээгдэхүүн гэж тооцогдохгүй.
 - Энэ баримт бичигт гарах “оролцогч этгээд” болон бусад нэр томъёоны тодорхойлолтыг ТННЭ-ийн нэр томъёоны тайлбар толиноос харна уу.
 - 'SFA Certified' бүтээгдэхүүний хууль ёсны өмчлөгч биш боловч тухайн бүтээгдэхүүнийг өмчлөгч этгээдийн нэрийн өмнөөс биечлэн хүлээн авдаг, хадгалдаг туслан гүйцэтгэгч нь тухайн оролцогч этгээдийн хамрах хүрээний гэрчилгээний бүртгэлд нэгжийн хувиар багтсан байх ёстой.
- 1.1.2 Зөвхөн тус бүртээ SFA шошготой эцсийн бэлэн бүтээгдэхүүн биечлэн хүлээн авдаг, хадгалдаг тохиолдолд брэнд болон жижиглэнгийн худалдаачдаас баталгаажуулалт шаардахгүй.
- Мэдэгдэл гаргахын тулд брэндүүд нь ТННЭ-д бүртгүүлэх шаардлагатай бөгөөд аливаа төлбөр хураамжийг төлсөн байна.
 - Баталгаажуулалт хийлгээгүй брэндүүдийн гаргах мэдэгдлийг ТННЭ нь хянах, зөвшөөрөл өгөх үүрэгтэй. Үүнийг ТННЭ-ийн Мэдэгдэл ба Логоны Зөвшөөрлийн маягт ([SFA Claims and Logo Approval Form](#)) ашиглан гүйцэтгэнэ.
 - Брэндүүдийн туслан гүйцэтгэгчид нь дуусгаагүй ба/эсвэл шошгогүй бүтээгдэхүүнийг биечлэн хүлээн авах эсвэл хадгалах тохиолдолд, тухайн брэнд эсвэл түүний туслан гүйцэтгэгчид нь өөрөө баталгаажсан байх шаардлагатай.
- 1.1.3 Хүснэгт 1-д заасан дүйцэх стандартын дагуу 'SFA Certified' бүтээгдэхүүнтэй харьцах хүчинтэй Хамрах хүрээний гэрчилгээтэй аливаа оролцогч этгээд нь тухайн стандартын шаардлага болон Хүснэгт 1-д заасан болзолыг хангасан тохиолдолд 'SFA Certified' бүтээгдэхүүний худалдаа, шошгожуулалт ба/эсвэл боловсруулалтын талаар мэдэгдэл гаргах **боломжтой**.
- Практикт, энэ нь Хүснэгт 1-д дурдсан стандартад нийцсэн гүйлгээг 2.9.1 ба 2.9.2 дахь шаардлагуудыг хангасанд тооцно гэсэн үг.

Стандарт	Тэмдэглэл
Textile Exchange Content Claim Standard	Оролцогч этгээд нь 'SFA Certified' бүтээгдэхүүнүүдийг бусад бүтээгдэхүүнээс тусгаарлах ба/эсвэл ялгарах шошго тэмдэглэгээ ашиглана.  Баталгаажгаагүй ноолууртай холихыг хориглоно.

- 1.1.4 ТННЭ эсвэл ТННЭ-ээс зөвшөөрөл авсан Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-уудын аль нэгнээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр хэн ч, ямар ч нөхцөлд 'SFA Certified' лого-г хуулбарлах, олшруулах эсвэл бусад хэлбэрээр ашиглах **боломжгүй**.
-  ТННЭ нь 'SFA Certified' мэдэгдэл, логог зөвшөөрөлгүй ашиглах эсвэл төөрөгдүүлсэн байдлаар хэрэглэсэн тохиолдлыг таслан зогсоох, арилгах хууль эрх зүйн бүхий л арга хэмжээг олон нийтэд ил тод хэрэгжүүлнэ.
- 1.1.5 Хэрэв энэхүү стандартад заасан шаардлага тухайн оролцогч этгээдийн үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн хууль тогтоомжтой зөрчилдөж байвал тухайн орон нутаг буюу харьяа газрын хуулийг нэн тэргүүнд **хэрэгжүүлнэ**.
-  Тухайн харьяа нутаг дэвсгэрээсээ гадуур үйл ажиллагаа явуулж буй нь тухайн оролцогч этгээдийн хувьд энэхүү заалтаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 1.1.6 'SFA Certified' бүтээгдэхүүний худалдаанд оролцож байгаа боловч уг бүтээгдэхүүнийг биечлэн эзэмшдэггүй оролцогч этгээдүүдийг 2.8-д заасан шаардлагаас **чөлөөлнө**.
-  Туслан гүйцэтгэгч нь тухайн оролцогч этгээдийн нэрийн өмнөөс 'SFA Certified' бүтээгдэхүүнийг биечлэн эзэмшиж байгаа тохиолдолд тухайн оролцогч этгээдийг 'SFA Certified' бүтээгдэхүүн биечлэн эзэмшдэг гэж үзнэ.
- 1.1.6.1 Энэ стандартын 2.8-д заасан шаардлагаас чөлөөлөгдсөн оролцогч этгээдийн аудитыг алсын зайнаас хийх **боломжтой**.
-  Энэ нь аудитын үлдсэн хэсгийг (жишээ нь 2.8-д зааснаас бусад шаардлагуудыг) алсын зайнаас хийх боломжтой гэсэн үг юм.
- 1.1.7 Энэхүү стандартын шаардлагын дагуу баталгаажуулалтанд хамрагдах хүсэлтэй эсвэл одоо байгаа баталгаажуулалтаа хадгалахыг хүссэн бүх малчдын байгууллагууд нь ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандартын хамгийн сүүлийн хувилбар эсвэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа өмнөх хувилбаруудын аль нэгээр баталгаажсан **байна**.
- 1.1.8 2024 оны 11-р сарын 1-нээс эхлэн 'SFA Certified' ноолуурыг угаах болон/эсвэл самнах үйл ажиллагаа явуулдаг энэхүү стандартын шаардлагын дагуу баталгаажуулалтанд хамрагдах хүсэлтэй эсвэл одоо байгаа баталгаажуулалтаа хадгалахыг хүссэн бүх үйлдвэрүүд ТННЭ-ийн Цэвэр Ноолуур Боловсруулах Стандарт-ын хамгийн сүүлийн хувилбар эсвэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа өмнөх хувилбаруудын аль нэгээр баталгаажсан **байна**.
-  Худалдагч этгээд нь ТННЭ-ийн бүх холбогдох стандартын шаардлагыг хангасан тохиолдолд л бүтээгдэхүүнүүд нь 'SFA Certified' байна.

2. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ШААРДЛАГА



2.1. Оролцогч этгээдийн бүтэц

2.1.1 Энэхүү стандартын дагуу баталгаажуулалтанд хамрагдах хүсэлтэй эсвэл одоо байгаа баталгаажуулалтаа хадгалахыг хүссэн бүх оролцогч этгээдүүд нь удирдлагын албатай **байна**.

■ Удирдлагын алба нь заавал биет оффистой байх шаардлагагүй.

2.1.2 Энэхүү стандартын дагуу баталгаажуулалтанд хамрагдах эсвэл одоо байгаа баталгаажуулалтаа хадгалахыг хүссэн бүх оролцогч этгээдүүд нь 'SFA Certified' бүтээгдэхүүнтэй биечлэн харьцдаг нэг болон түүнээс дээш нэгжтэй байх боломжтой.

■ Туслан гүйцэтгэгчийн хариуцаж буй нэгжүүд ч үүнд хамаарна.

2.2. Оролцогч этгээдийн эрх зүйн статус

2.2.1 Энэхүү стандартын дагуу баталгаажуулалтанд хамрагдах эсвэл одоо байгаа баталгаажуулалтаа хадгалахыг хүссэн бүх оролцогч этгээдүүд нь удирдлагын алба нь байрлах тухайн улсад харьяалалтай хуулийн этгээд эсвэл хувь хүн **байна**.

2.2.2 Оролцогч этгээдүүд нь энэхүү стандартын шаардлагуудыг тусгасан гэрээ бэлтгэж, тухайн оролцогч этгээдийн Хамрах хүрээний гэрчилгээнд бичигдэх бүх нэгжүүдтэй **гэрээлнэ**.

■ Үүнд оролцогч этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй бүх туслан гүйцэтгэгчид ч хамрагдана.

2.3. Баримтжуулсан журам

2.3.1 Оролцогч этгээд нь ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын шаардлага бүрийг тасралтгүй, тууштай хангах зорилгоор үйл явц (процесс), шат дараалал (процедур), үүрэг хариуцлагыг баримтжуулан тодорхойлсон чанарын удирдлагын систем нэвтрүүлж, **мөрдөнө**.

2.3.2 Оролцогч этгээд нь өөрийн Хамрах хүрээний гэрчилгээнд бичигдэх нэгжийг нэмэх, хасах тодорхой журамтай байна. Энэхүү журамд туслан гүйцэтгэгчдийн хариуцаж буй нэгжүүдийг ч **багтаана**.

2.3.3 Оролцогч этгээд нь энэхүү стандарттай холбоотой санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх журамтай байх бөгөөд хэрэгжилтийг ханган **ажиллана**.

2.3.4 Оролцогч этгээд нь шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг 'SFA Certified' гэж санамсаргүйгээр худалдах болон нийлүүлэхээс сэргийлэхийн тулд тэдгээрийг илрүүлэх, хянах журмыг **хэрэгжүүлнэ**.

2.4. Нөөц болон сургалт

- 2.4.1 Оролцогч этгээд нь ТННЭ-ийн Мөшгөлтийн Тогтолцооны Стандартын шаардлага бүрийг тасралтгүй, тууштай хангахад шаардлагатай хүний нөөц болон дэд бүтцийн нөөцийг бүрдүүлэн **ажиллана**.
- 2.4.2 Оролцогч этгээд нь ТННЭ-ийн Мөшгөлтийн Тогтолцооны Стандартын шаардлагуудыг хангах ерөнхий үүрэг, хариуцлагыг хүлээсэн удирдлагын төлөөлөгчийг **томилно**.
- 2.4.2.1 Оролцогч этгээд нь удирдлагын төлөөлөгчтэй холбоотой аливаа өөрчлөлтийг ажлын 10 хоногийн дотор Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ) болон ТННЭ-д мэдэгдэнэ.
- 2.4.3 Оролцогч этгээд нь эдгээр шаардлагыг биелүүлэхтэй холбоотой журам бүрийн хэрэгжилтийг хариуцах үндсэн ажилтнуудыг тодорхойлж, **томилно**.
- 2.4.4 Оролцогч этгээд нь ТННЭ-ийн Мөшгөлтийн Тогтолцооны Стандартын шаардлагыг хангуулах үүрэг хүлээсэн бүх ажилтнуудаа өөрийн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай зохих сургалтад хамруулж, мэргэжлийн үр чадвар **эзэмшүүлнэ**.

2.5. Менежментийн системийн хяналт

- 2.5.1 Оролцогч этгээд нь жил бүр өөрийн мөшгөлтийн тогтолцооны менежментийн системийг хянаж, шалгалт хийх бөгөөд үүнд дараахыг **хамруулна**:
- a. Стандартын шаардлагын дагуу хийсэн өөрийн үнэлгээ;
 - b. Өмнөх хяналтаас хойш оролцогч этгээд, түүний нэгжүүд эсвэл бүтээгдэхүүний талаар аливаа хувь хүн, хуулийн этгээдийн дэвшүүлсэн шийдэгдээгүй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн, нэн ялангуяа хамгийн сүүлд хийсэн өөрийн үнэлгээнээс хойш ирсэн гомдол тус бүрт чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө;
 - c. Өмнөх хяналтын үед шийдвэрлэгдээгүй байсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн нэн яаралтай хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг гомдол тус бүрээр нь гаргасан байна.

2.6. Бүртгэл хөтлөлт

- 2.6.1 Оролцогч этгээд нь доорх бүртгэлийг бүрэн, үнэн зөвөөр, шинэчилсэн байдлаар **хөтөлнө**:
- a. Оролцогч этгээдийн нэрийн өмнөөс "SFA Certified" бүтээгдэхүүнтэй биечлэн харьцаж байгаа бүх нэгжийн нэр, хаяг, холбоо барих мэдээлэл болон үйл ажиллагааны бүртгэл. Үүнд жижиглэн худалдаалах нэгж (салбар)-үүд хамаарахгүй;
 Тус бүртгэлд туслан гүйцэтгэгчийн хариуцаж буй нэгжүүд ч хамаарна.
 - b. Нэгж (малчин өрх) бүрийн үйлдвэрлэсэн бүх 'SFA Certified' ноолуурын тоо хэмжээ, хэрэв байгаа бол үйлдвэрлэгдсэн огнооны хамт;
 - c. Нэгж (малчин өрх) бүрийн худалдан авсан, борлуулсан ямааны тоо, хэрэв байгаа бол;
 - d. 'SFA Certified' бүтээгдэхүүний боловсруулалт ба/эсвэл чийгшүүлэхтэй холбоотой бүх мэдээлэл, үүнд дараах мэдээллүүд багтах ба үүгээр хязгаарлагдахгүй:
 - i. Боловсруулалтын бүртгэлүүд;
 - ii. бүтээгдэхүүний чанарын шинжилгээтэй холбоотой аливаа өгөгдөл, тайлангууд;
 - e. 'SFA Certified' бүтээгдэхүүний гүйлгээтэй холбоотой бүх мэдээлэл. Үүнд дараах мэдээллүүд багтах ба үүгээр хязгаарлагдахгүй:
 - i. Гүйлгээний бүртгэл;
 - ii. Оролцогч этгээдийн гаргасан мэдэгдэл;
 - iii. Гэрээнүүд;

- iv. бүтээгдэхүүний тодорхойлолт эсвэл техникийн үзүүлэлтийг харуулсан дэлгэрэнгүй мэдээлэл;
 - v. худалдан авах захиалга;
 - vi. нэхэмжлэл, гүйлгээний баримт;
 - vii. тээвэр, гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бичиг баримтууд;
 - viii. Оролцогч этгээдэд 'SFA Certified' бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн нэр, хаяг болон холбоо барих мэдээлэл;
 - ix. Оролцогч этгээдээс 'SFA Certified' бүтээгдэхүүн худалдан авагчдын нэр, хаяг болон холбоо барих мэдээлэл;
 - x. 'SFA Certified' бүтээгдэхүүн тээвэрлэгдэн ирэх үеийн үзлэг шалгалт.
- f. Оролцогч этгээдийн эзэмшлээс гарах хүртэлх хугацаанд худалдаж авсан ба/эсвэл үйлдвэрлэсэн бүх 'SFA Certified' бүтээгдэхүүний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, үүнд дараах зүйлс багтана:
- i. Бараа, бүтээгдэхүүний хувиар илэрхийлсэн тоо хэмжээ, үүнд:
 - i. Нөөцөд байгаа бүтээгдэхүүн;
 - ii. 'SFA Certified' бүтээгдэхүүн хэлбэрээр борлуулагдсан;
 - iii. баталгаажуулаагүй бүтээгдэхүүн хэлбэрээр борлуулагдсан;
 - iv. боловсруулалтын явцад хог хаягдал болон хаягдсан; эсвэл
 - v. бусад байдлаар хаягдсан/буцаагдсан бүтээгдэхүүн орно.
 - ii. Боломжтой бол нэгж (салбар) тус бүрээр салгаж бүртгэнэ;
-  *Оролцогч этгээд нь ТННЭ-ийн Цэвэр Ноолуур Боловсруулах Стандартын хүрээнд шаардаагүй бол худалдан авагчид очсоны дараах борлуулалт эсвэл устгасан хог хаягдлыг хянах шаардлагагүй.*
- g. Бүтээгдэхүүнд багтсан 'SFA Certified' ноолуур нь 100%-иас бага байх тохиолдолд бүтээгдэхүүний агууламжийн мэдэгдэлд ашигласан тэгшитгэл;
 - h. Санал гомдлууд, мөн шийдвэрлэгдсэн санал гомдлуудын хувьд тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх тайлбар болон гарсан үр дүнгийн дэлгэрэнгүй;
 - i. ТННЭ-ийн баталгаажуулалттай холбоотой ажилтнуудад хийгдсэн сургалт;
 - j. Энэхүү стандартын биелэлтийг харуулах бусад бүртгэл.

2.6.1.1 Оролцогч этгээд нь бүртгэлийг хялбар, хүртээмжтэй байлгаж тэдгээрт дүн шинжилгээ хийх боломжыг **бүрдүүлнэ**.

 *Өгөгдөл, мэдээлэл нь биет баримт бичгийн сканердсан хуулбараас гадна MS Excel зэрэг өгөгдлийн санд хадгалагдсан байх.*

2.6.2 Гүйлгээний бүртгэл нь дараах мэдээллийг агуулсан **байна**:

- a. Гүйлгээ хийгдэж буй баталгаажсан ноолуурын тоо, хэмжээ (certified cashmere);
- b. Гүйлгээ хийгдэж буй ноолуурын нийт тоо, хэмжээ (gross cashmere);
- c. Гүйлгээ хийгдэж буй ноолуурын цэвэр тоо, хэмжээ (net cashmere);
- d. Түүхий ноолуурын гүйлгээний бүртгэлийн хувьд, гарал үүсэл бүс нутаг болон улс;
- e. Түүхий ноолуурын гүйлгээний бүртгэлийн хувьд, ноолуурыг нь самнасан ямааны дундаж нас;
- f. Түүхий ноолуурын гүйлгээний бүртгэлийн хувьд, гүйлгээ хийгдэж буй ноолуурын микрон;
- g. Түүхий ноолуурын гүйлгээний бүртгэлийн хувьд, гүйлгээ хийгдэж буй ноолуурын өнгө;

- h. Бүтээгдэхүүнийг тээвэрлэж эхэлсэн он, сар, өдөр;
 - i. Бүтээгдэхүүнийг хүлээн авсан он, сар, өдөр;
 - *Үүнийг худалдан авагч тал баталгаажсан бүтээгдэхүүн(үүд)-ийг хүлээн авсны дараа оруулна.*
 - j. Худалдагч талын ТННЭ-ийн Мөшгөлтийн Тогтолцооны Стандартын хамрах хүрээний гэрчилгээний дугаар;
 - k. Гүйлгээний бүртгэлийг бөглөж буй худалдагч талын төлөөлөгчийн бүтэн нэр;
 - l. Худалдан авагчийн ТННЭ-ийн Мөшгөлтийн Тогтолцооны Стандартын хамрах хүрээний гэрчилгээний дугаар, хэрэв байгаа бол;
 - m. Гүйлгээний бүртгэлийг бөглөж буй худалдан авагчийн төлөөлөгчийн бүрэн нэр;
 - n. Гүйлгээний дараа бүтээгдэхүүнийг биечлэн эзэмших худалдан авагчийн нэгж (салбар)-ийн жагсаалт;
 - o. Тухайн гүйлгээнд орж буй 'SFA Certified' бүтээгдэхүүний өмнө хийгдсэн гүйлгээнүүдийн бүртгэлийн жагсаалтыг гаргана. Ингэхдээ өмнө хийгдсэн гүйлгээ бүрээс тухайн гүйлгээнд багтан орсон байгаа баталгаажсан бүтээгдэхүүний тоо, хэмжээг харуулсан байна;
 - *Өмнө хийгдсэн гүйлгээ гэдэгт зөвхөн тухайн гүйлгээний яг өмнөх шатанд хийгдсэн гүйлгээг авч үзнэ. Үүнд худалдагч тал баталгаажсан бүтээгдэхүүн худалдан авахаас өмнөх үеийн гүйлгээнүүдийг авч үзэхгүй.*
 - p. Худалдагч талын зүгээс тухайн борлуулж буй бүтээгдэхүүнд хийсэн аливаа боловсруулалт ба/эсвэл чийгшүүлэлтэй холбоотой Боловсруулалтын бүртгэлийн жагсаалт;
 - q. Гүйлгээний дахин давтагдахгүй дугаар;
 - *Дахин давтагдахгүй дугаарыг [SFA Traceability Platform](#) - оос гаргана.*
 - r. Худалдан авагч болон худалдагч талууд тухайн гүйлгээний бүртгэлийг бүрэн хийгдсэн гэж зөвшилцсөн огноо;
 - s. ТННЭ-ийн хэмжээнд суурилсан хураамж (SFA Volume Based Fee) төлөгдсөн эсэх.
- 2.6.3 Боловсруулалтын бүртгэл нь дараах мэдээллийг агуулсан **байна**:
- a. Боловсруулалт ба/эсвэл чийгшүүлэлтээс өмнөх баталгаажсан ноолуурын хэмжээ;
 - b. Тухайн боловсруулалт ба/эсвэл чийгшүүлэлт хийгдэж буй 'SFA Certified' бүтээгдэхүүний өмнө хийгдсэн гүйлгээнүүдийн бүртгэлийн жагсаалтыг гаргана. Ингэхдээ өмнө хийгдсэн гүйлгээ бүрээс авсан баталгаажсан бүтээгдэхүүний тоо, хэмжээг харуулсан байна;
 - c. Боловсруулалт ба/эсвэл чийгшүүлэлтийн дараах баталгаажсан ноолуурын хэмжээ;
 - d. Боловсруулалт ба/эсвэл чийгшүүлэлтийн өмнөх ноолуурын төлөв байдлын үзүүлэлт;
 - e. Хийгдэж буй боловсруулалт болон/эсвэл чийгшүүлэлтийн төрөл, түүний үзүүлэлт;
 - f. Боловсруулалт ба/эсвэл чийгшүүлэлтийн дараах ноолуурын төлөв байдлын үзүүлэлт;
 - g. Боловсруулалт ба/эсвэл чийгшүүлэлтийн дараах баталгаажсан ноолуурын хэмжээг тооцоолоход ашигласан чийг шингээх фактор;
 - h. Боловсруулалт ба/эсвэл чийгшүүлэлтийн дараа баталгаажсан ноолуурын хэмжээг тооцоход ашигласан бодит хөрвүүлэх факторууд;
 - i. Боловсруулалт ба/эсвэл чийгшүүлэлт хийгдэж буй баталгаажсан ноолуурын хэмжээг тооцоход ашигласан чийг шингээх фактор ба/эсвэл хөрвүүлэгч факторуудын үндэслэл;
 - j. Энэхүү боловсруулалтын бүртгэлийг хөтөлсөн оролцогч этгээдийн төлөөлөгчийн бүтэн нэр;

- к. Тухайн боловсруулалтанд хамаарах дахин давтагдахгүй дугаар;
■ *Дахин давтагдахгүй дугаарыг [SFA Traceability Platform](#)-оос олгодог.*

л. Боловсруулалтын бүртгэлийг оролцогч этгээдийн ТҮБ баталгаажуулсан огноо.

2.6.4 Бүртгэлийг зургаан жилээс доошгүй хугацаагаар **хадгална**.

2.7. Тайлан ба ил тод байдал

2.7.1 Оролцогч этгээд нь ТННЭ ба/эсвэл оролцогч этгээдийн Хамрах хүрээний гэрчилгээ олгогч ТҮБ болон тэдний төлөөлөгчдийн хүсэлтийн дагуу оролцогч этгээдийн ба/эсвэл туслан гүйцэтгэгчийн бүх бүртгэл, хамрах хүрээний гэрчилгээнд хамаарах нэгж, ажилчдын талаарх мэдээлэлд ямар нэгэн нөхцөл, хязгаарлалт тавилгүйгээр хандах боломжийг **олгоно**.

2.7.2 Оролцогч этгээд нь баталгаажуулалт авсан ТННЭ-ийн стандартуудын аль нэгийнх нь эсрэг оролцогч этгээдийн гаргасан байж болзошгүй үл тохиролын сэжигтэй тохиолдлыг оролцогч этгээдийн ТҮБ-д мэдээллэхийг нийт ажилтнууддаа **уриална**.

2.7.2.1 Оролцогч этгээд нь ажилтнуудын цуглардаг ил харагдах газруудад дараах мэдэгдлийг **байрлуулна**:

- а. Оролцогч этгээдийн баталгаажуулалт авсан ТННЭ-ийн стандартуудын жагсаалт;
■ *үүнд ТННЭ-ийн Мөшгөлтийн Тогтолцооны Стандарт багтана;*
- б. Оролцогч этгээдийн баталгаажуулалт авсан ТННЭ-ийн стандартын талаарх нэмэлт мэдээллийг хэрхэн авах талаарх мэдээлэл;
- в. Оролцогч этгээдийн баталгаажуулалт авсан ТННЭ-ийн стандартуудын аль нэгийнх нь эсрэг оролцогч этгээдийн гаргасан байж болзошгүй үл тохирлын сэжигтэй тохиолдлыг тухайн оролцогч этгээдийн ТҮБ-д шууд мэдээлэх талаар нийт ажилтнууд зориулсан зааварчилгаа;
- д. Оролцогч этгээдийн ТҮБ-тай холбоо барих мэдээлэл;
- е. Ажилтнуудын ТҮБ-д хандсан бүх мэдээлэл нь нууцлалтай байх бөгөөд ямар нэг хувийн мэдээллийг оролцогч этгээдэд дамжуулахгүй болохыг баталгаажуулсан мэдэгдэл.

2.7.2.1.1 Мэдэгдлийг энгийн, ойлгомжтой байдлаар, ажилтнуудын түгээмэл ашигладаг хэлээр бичсэн **байна**.

2.8. Боловсруулалт, хадгалалт ба тээвэрлэлт

2.8.1. Оролцогч этгээд нь 'SFA Certified' бүтээгдэхүүний аливаа боловсруулалт ба/эсвэл чийгшүүлэлтийг цахим "Боловсруулалтын бүртгэл"-ээр баримтжуулж, бүртгэлийг бүрэн **хийнэ**.

2.8.1.1. Бодит хөрвүүлэлтийн фактор нь таамагласан хөрвүүлэлтийн фактороос 5%-иас илүү зөрүүтэй байгаа тохиолдолд "Боловсруулалтын бүртгэл"-д орсон мэдээллийг ТҮБ үнэн зөв болохыг **баталгаажуулна**.

■ *Боловсруулалтын төрлүүдийг Хүснэгт 2-т үзүүлэв.*

2.8.2. Оролцогч этгээд нь өөрийн эзэмшилд буй бүтээгдэхүүнд зориулан бүтээгдэхүүнийг таних, тэдгээрийн орц, материалыг хянах журмыг боловсруулж тогтмол **мөрдүүлнэ**.

■ *Тус журамд хоорондоо ижил төстэй боловч баталгаажсан болон баталгаажгаагүй гэдгээрээ ялгаатай бүтээгдэхүүнийг багтаана. Эдгээр бүтээгдэхүүнүүдэд орсон материалуудын төлбөрийн баримт тус тусдаа байна.*

2.8.3. Оролцогч этгээд нь 'SFA Certified' бүтээгдэхүүнүүдийг баталгаажгаагүй бүтээгдэхүүнээс бүх цаг үед амархан ялгаж танигдахуйц тодорхой хаяг, шошготой **байлгана**.

- 2.8.4. Оролцогч этгээд нь өөрсдийн өмчлөлд байгаа, биечлэн хадгалж буй бүх 'SFA Certified' бүтээгдэхүүнүүдийг шошгожуулж, тухайн багцын гүйлгээний бүртгэл, боловсруулалтын бүртгэл болон бусад бүх баримт бичигтэй холбож болохуйц байдлыг **хангана**.
- 2.8.5. 'SFA Certified' аливаа бүтээгдэхүүнд орсон нийт ноолуур нь 100% 'SFA Certified' **байна**.
■ *'SFA Certified' ноолуурыг баталгаажуулах шаардлагагүй бусад ширхэгтэй хольж хэрэглэж болно.*
- 2.8.6. Оролцогч этгээд нь 'SFA Certified' бүтээгдэхүүнийг баталгаажуулах ноолууран бүтээгдэхүүнээс үргэлж тусгаарлаж **байлгана**.
■ *Энэ нь нийлүүлэлтийн сүлжээний бүх шатанд, боловсруулалт, тээвэрлэлтийн үед ч хамаарна.*
- 2.8.7. Оролцогч этгээд нь 'SFA Certified' бүтээгдэхүүнд хэрэглэхийн өмнө аливаа тоног төхөөрөмжийг баталгаажуулах бүтээгдэхүүнээс бүрэн цэвэрлэсэн **байна**.
- 2.8.8. Оролцогч этгээд нь 'SFA Certified' бүтээгдэхүүний сав баглааг ямар нэг байдлаар өөрчлөгдсөн, нээгдсэн, гээгдсэн/солигдсон эсвэл гэмтээсэн эсэхийг хүлээн авагч тал шууд мэдэхүйц байдлаар битүүмжилсэн **байна**.

2.9. Гүйлгээ

- 2.9.1. Оролцогч этгээд нь зөвхөн хүчинтэй Хамрах хүрээний гэрчилгээтэй оролцогч этгээдээс 'SFA Certified' бүтээгдэхүүн худалдан **авна**.
- 2.9.2. Оролцогч этгээд нь худалдан авч буй бүтээгдэхүүнд орсон 'SFA Certified' бүтээгдэхүүний худалдан авалтын түүхийг илтгэх хүчинтэй Гүйлгээний Бүртгэлгүйгээр 'SFA Certified' бүтээгдэхүүн худалдан авахыг **хориглоно**.
- 2.9.3. Оролцогч этгээд нь хүлээн авсан бүх биет 'SFA Certified' бүтээгдэхүүнүүд нь тухайн бүтээгдэхүүний худалдан авалтын Гүйлгээний Бүртгэлд дурдсан мэдээлэлтэй таарч байгаа эсэхийг **баталгаажуулна**.
- 2.9.4. Хэрэв оролцогч этгээд нь 'SFA Certified' бүтээгдэхүүн гэж худалдаалсан боловч баталгаажуулах бүтээгдэхүүн хүлээн авсан бол, тухайн бүтээгдэхүүн баталгаажуулах болохыг мэдсэн өдрөөс хойш ажлын таван хоногийн дотор ТҮБ болон ТННЭ-д **мэдээлнэ**.
■ *ТННЭ-д мэдээлэхдээ дараах хаяг руу бичнэ үү: standards@sustainablefibre.org.*
- 2.9.4.1. Хэрэв бүтээгдэхүүнийг аль хэдийн борлуулсан бол, тухайн бүтээгдэхүүн баталгаажуулах болохыг мэдсэн өдрөөс хойш ажлын таван хоногийн дотор худалдан авагчид **мэдээлнэ**.
- 2.9.5. Оролцогч этгээд нь тухайн бүтээгдэхүүнд ямар нэгэн боловсруулалт хийж эхлэхээс өмнө эсвэл дахин худалдаалахаас өмнө тухайн бүтээгдэхүүний Гүйлгээний Бүртгэл-ийн эцсийн дэлгэрэнгүй мэдээллийг доор дурьдсан талуудад нээлттэй **байлгана**:
- Худалдан авагч;
 - Худалдагч тал;
 - Худалдан авагчийн Хамрах хүрээний гэрчилгээг олгосон ТҮБ;
 - Худалдагч талын Хамрах хүрээний гэрчилгээг олгосон ТҮБ;
 - ТННЭ
- 2.9.6. Доорх бүтээгдэхүүний хувьд худалдан авагч эсвэл худалдагч талын ТҮБ-ийн зүгээс "Гүйлгээний бүртгэл"-ийн дэлгэрэнгүй мэдээлэл үнэн зөв ба энэ гүйлгээний өмнөх нийлүүлэлтийн сүлжээний шат дамжлага бүрт тоо хэмжээний тохируулга нь үнэн зөв хийгдсэн гэдгийг баталгаажуулсан хүчин төгөлдөр баталгааг авахаас өмнө худалдан авсан бүтээгдэхүүнийг борлуулахгүй эсвэл боловсруулалтыг эхлүүлэхийг **хориглоно**:
- Оролцогч этгээдүүд хооронд зарагдсан түүхий ноолуур;

b. Нэг хамрах хүрээний гэрчилгээн дээр байхгүй оролцогч этгээд болон нэгж (малчин өрх)-ийн хооронд худалдаалагдсан түүхий ноолуур;

c. Самнах буюу хялгас ялгах дамжлагаас хойш борлуулагдаагүй ноолуур.

■ Оролцогч этгээд хамрах хүрээний гэрчилгээ дээр бүртгэгдээгүй өөр нэгжээс түүхий ноолуураас бусад ноолуур (боловсруулсан)-ын гүйлгээ хийсэн эсвэл самнасан буюу хялгас ялгаснаас хойш борлуулагдаагүй ноолуурыг зарах эсвэл боловсруулалт хийж болно. Гэхдээ оролцогч этгээд нь аудитын үеэр ТҮБ-ийн зүгээс “Гүйлгээний Бүртгэл”-ийн мэдээллийг эсвэл тоо хэмжээний тохируулгыг баталгаажуулах боломжгүй гэж үзвэл тухайн бүтээгдэхүүн нь ‘SFA Certified’ гэж тооцогдохгүй болох эрсдэлийг оролцогч этгээд өөрөө хариуцна гэж үзвэл энэ төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалж, боловсруулах нь нээлттэй.

■ ТҮБ-ууд нь хийгдсэн гүйлгээ бүрээс хойш нэг сарын дотор бүх гүйлгээнд аудит хийх шаардлагатай.

2.9.7. Оролцогч этгээд нь бүтээгдэхүүнд орсон ноолуурын 100% нь ‘SFA Certified’ биш бол тухайн бүтээгдэхүүнийг ‘SFA Certified’ гэж худалдаалахыг **хориглоно**.

2.9.8. Ноолуураас бусад ширхэгтэй ‘SFA Certified’ ноолуурыг хольсон тохиолдолд, тухайн бүтээгдэхүүн дэх ноолуурын 100% нь ‘SFA Certified’ биш эсвэл эцсийн бүтээгдэхүүний найрлагад ‘SFA Certified’ ноолуурын эзлэх хувь нь хамгийн багадаа 5%-ийг бүрдүүлээгүй бол бүтээгдэхүүнийг ‘SFA Certified’ гэж худалдаалахыг **хориглоно**.

■ Жишээлбэл, 95% ноос, 5% ноолуураас бүрдсэн ороолт байна гэвэл тус 5% ноолуур нь ‘SFA Certified’ ноолуур байх ёстой. Ондoo жишээ авбал, 70% торго, 30% ноолуураас бүрдсэн ороолт гэвэл нийт бүтээгдэхүүний 30% нь ‘SFA Certified’ ноолуур байх ёстой.

2.9.9. Оролцогч этгээд нь ‘SFA Certified’ бүтээгдэхүүний аливаа борлуулалт бүрийг цахим “Гүйлгээний бүртгэл”-ээр баримтжуулж, худалдан авагч бүтээгдэхүүнийг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногт багтаан тус бүртгэлийг бүрэн хийж, тусгагдсан мэдээллийг худалдан авагч болон худалдагч тал харилцан зөвшөөрсөн **байна**.

■ ‘SFA Certified’ бүтээгдэхүүн худалдаалах бүрт “Гүйлгээний бүртгэл” бөглөх шаардлагатай. Дутуу бөглөгдсөн “Гүйлгээний бүртгэл”-ийг хүчингүйд тооцно.

2.10. Тоо хэмжээний тохируулга

2.10.1. Оролцогч этгээд нь нэгж тус бүрээс ирсэн болон гарсан материалуудын талаарх шинэчилсэн тоо бүртгэл хөтөлнө. Энэхүү бүртгэл нь нэгж бүрд ирсэн материалын тоо хэмжээ нь тухайн нэгжээс гарч буй материалын тоо хэмжээтэй тохирч байгааг бататгах тооцооллыг харуулах ба тус тооцоололд хөрвүүлэх фактор болон чийгшүүлэлтийг мөн харгалзан **үзнэ**.

■ Ирсэн материал (Орц) гэдэг нь худалдан авсан ‘SFA Certified’ бүтээгдэхүүний хэмжээг илэрхийлнэ. Гарсан материал (Гарц) нь ‘SFA Certified’ бүтээгдэхүүний үлдэгдэл, ‘SFA Certified’ гэж худалдаалсан бүтээгдэхүүн, баталгаажаагүй хэлбэрээр худалдаалсан бүтээгдэхүүн, боловсруулалтын явцад гарсан хаягдал, эсвэл өөр ямар нэгэн шалтгаанаар хаягдсан/буцаагдсан бүтээгдэхүүнийг хамарна.

2.10.2. Түүхий ноолуур бэлтгэн нийлүүлж буй оролцогч этгээд нь бэлтгэсэн ноолуурын хэмжээг мэдэгдэж буй ямааны тоо толгойтой харьцуулан тооцох замаар баталгаажсан ноолуурын үйлдвэрлэлд нотолгоо **гаргана**.

■ Энэ нь зөвхөн ноолуур бэлтгэн нийлүүлж буй оролцогч этгээдэд хамаарна.

2.10.3. Оролцогч этгээд нь хөрвүүлэх фактор(ууд)-ыг тооцох болон чийгшүүлэлтийн нөлөөг үнэлэх тогтмол аргачлалтай байж, уг аргыг ашиглан факторуудыг тогтмол **шинэчилнэ**.

2.10.4. SFA Certified" шошготой зарагдсан баталгаажсан бүтээгдэхүүний тоо хэмжээ (хөрвүүлэх фактор болон чийгшүүлэлтийг тооцсон байдлаар) нь нэгж (малчин өрх)-ийн түвшинд самнаж авсан эсвэл худалдаж авсан "SFA Certified" бүтээгдэхүүний тоо хэмжээнээс огт

хэтрэхгүй байхыг оролцогч этгээд **хариуцна**.

2.10.5. Оролцогч этгээд нь Хүснэгт 2-д жагсаасан боловсруулалтын төрлүүдэд хийсэн аливаа боловсруулалтын шатанд ашиглах хөрвүүлэлтийн факторыг үндэслэлтэйгээр **тайлбарлана**.

 Ялангуяа, шинэ оролцогч этгээдийн анхны үнэлгээний үед.

2.10.6. Оролцогч этгээд нь тооцоолсон хөрвүүлэх факторыг өмнө жилийн бодит хөрвүүлэлтийн дараах хэмжээтэй харьцуулах замаар хөрвүүлэлтийг тооцох аргачлалдаа жил бүр хяналт, шалгалт хийж, гарсан аливаа өөрчлөлтийг **тайлбарлана**.

2.10.7. Оролцогч этгээд нь тооцоолсон чийгшүүлэлтийн нөлөөг өмнө жилийн бодит чийгшүүлэлтийн нөлөөтэй харьцуулах замаар тооцох аргачлалдаа жил бүр хяналт, шалгалт хийж, гарсан аливаа өөрчлөлтийг **тайлбарлана**.

2.10.8. Оролцогч этгээд нь худалдаж авсан болон борлуулсан материалын зөрүү нь хөрвүүлэх факторууд болон чийгшүүлэлтийг харгалзан үзсэний дараа 5%-аас дээш гарсан тохиолдолд 'SFA Certified' бүтээгдэхүүн бүрд тайлбар **өгнө**.

2.10.8.1. Чийгшүүлэлтийн тооцооллоо ноолуурын дээжинд хийсэн чийгийн агууламжийн шинжилгээд үндэслэн **тайлбарлана**.

Хүснэгт 2: Боловсруулалтын төрлүүд. Эдгээрт ашиглах хөрвүүлэлтийн факторыг ТҮБ-тэй зөвшилцсөний үр дүнд сонгоно.

	Боловсруулалтын төрлүүд
Түүхий эд бэлтгэл	Хяргах
	Самнах
Анхан шатны боловсруулалт	Ангилан ялгах
	Хяргасан ноолуур угаах
	Хяргасан ноолуурын хялгас ялгах (самнах)
	Самнасан ноолуур угаах
	Самнасан ноолуурын хялгас ялгах (самнах)
Үйлдвэрлэл	Бүдүүн ээрэх
	Нарийн ээрэх
	Нэхэх
	Сүлжих
	Нойтон боловсруулалт
	Будах
	Бусад үйлдвэрлэл
Бусад	Дахин боловсруулах
	Чийгшүүлэлт

2.11. Мэдэгдэл

- 2.11.1 Оролцогч этгээд нь 'SFA Certified' мэдэгдлийг зөвхөн үнэн бодитой, баталгаажуулах боломжтой тохиолдолд л **гаргана**.
- 2.11.2 Оролцогч этгээд нь байгаль орчин, нийгэм, малын тавлаг байдалтай холбогдуулсан ерөнхий, өргөн хүрээний мэдэгдэл гаргахыг **хориглоно**.
- Жишээлбэл, “ёс зүйтэй үйлдвэрлэгдсэн” (*ethically produced*), “яргалалтаас ангид” (*cruelty free*), “байгаль орчинд ээлтэй” (*environmentally friendly*) эсвэл “100% тогтвортой” (*100% sustainable*) зэрэг мэдэгдлүүд гаргахыг зөвшөөрөхгүй.
- 2.11.3 Оролцогч этгээдийн бүх мэдэгдэлд дараах мэдээлэл багтсан **байна**:
- оролцогч этгээдийн нэр;
 - оролцогч этгээдийн хамрах хүрээний гэрчилгээний дугаар; болон
 - ТННЭ-г иш татсан байх.
- 2.11.4 Оролцогч этгээд нь тухайн бүтээгдэхүүний гарал үүсэл болох улсын нэрийг дурдалгүйгээр газарзүйн байршил бүхий 'SFA Certified' мэдэгдэл гаргахыг **хориглоно**.
- 2.11.5 Оролцогч этгээд нь ямар нэг байдлаар ТННЭ-ийн баталгаажуулалттай холбоогүй ондоо бүтээгдэхүүн дээр тухайн бүтээгдэхүүн нь 'SFA Certified' гэж ойлгогдох агуулга бүхий ташаа мэдэгдэл гаргахыг **хориглоно**.
- 2.11.6 Оролцогч этгээд нь 'SFA Certified' лого бүхий мэдэгдэл гаргахдаа ТННЭ-ийн Брендийн таниулах удирдамжийг мөрдлөг **болгоно**.
- 2.11.7 'SFA Certified' логог ашиглахад ТННЭ-ийн талаарх шаардлага хангасан тодорхой мэдээллийг агуулсан байвал зохино.
- Энэ нь хэрэглэгчдэд бидний ажлын талаархи ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд оршино.
- 2.11.8 Оролцогч этгээд нь тухайн мэдэгдэлтэй холбоотойгоор ТҮБ-ээс урьдчилж зөвшөөрөл авалгүйгээр 'SFA Certified' мэдэгдэл гаргахыг **хориглоно**.
- 2.11.8.1 Хүснэгт 3-т урьдчилан бэлтгэсэн мэдэгдлүүд нь 2.11.8 дахь шаардлагаас чөлөөлөгдөх бөгөөд эдгээрийг ашиглах тохиолдолд ТҮБ-ээс урьдчилж зөвшөөрөл авахыг **шаардахгүй**.
- 2.11.8.2 Урьдчилан бэлтгэсэн мэдэгдлийг өөр хэлрүү орчуулсан тохиолдолд ашиглахаас өмнө ТҮБ-ээс урьдчилж зөвшөөрөл **авна**.
- Урьдчилан бэлтгэсэн мэдэгдлүүд нь энэхүү бүлэгт тусгагдсан бүх шаардлагыг хангасан байна.
 - Урьдчилан бэлтгэсэн мэдэгдэл, ерөнхий мэдэгдэл, бүтээгдэхүүний мэдэгдэл болон шаардлага хангасан мэдэгдлүүд (Хүснэгт 3-ийг харна уу)-ийн талаарх дэлгэрэнгүйг ТННЭ-ийн нэр томъёоны тайлбар тольд тодорхойлсон.
- 2.11.9 Оролцогч этгээд нь зөвхөн дараах тохиолдолд тодорхой бүтээгдэхүүнд зориулж 'SFA Certified' мэдэгдэл **гаргана**:
- тухайн бүтээгдэхүүнд орсон бүх материалын хувьд хүчинтэй, мөшгөх боломжтой “Гүйлгээний Бүртгэл”-үүд байгаа тохиолдолд;
 - тухайн онцлог бүтээгдэхүүн нь тухайн оролцогч этгээдийн өөрийн эзэмшдэг бүтээгдэхүүн байх;
 - Өөр оролцогч этгээдийн эзэмшдэг бүтээгдэхүүн дээр мэдэгдэл гаргах бол тухайн этгээдийг баталгаажсан байхыг шаардана.
 - ТҮБ-тэй зөвшилцсөнөөс бусад тохиолдолд тухайн бүтээгдэхүүн дээрх мэдэгдэлд 'SFA Certified' лого багтсан байх;
 - 'SFA Certified' лого нь бүтээгдэхүүний бичвэр мэдэгдлийн хамт харагдах боломжгүй

тохиолдолд (жишээлбэл: онлайн каталогийн зураг) ТҮБ-ын зүгээс зөвхөн бичвэр мэдэгдэл гаргахыг зөвшөөрч болно. Гэхдээ ТННЭ-ийн лого тухайн бүтээгдэхүүн дээр, шошго дээр, бүтээгдэхүүний катологи, эсвэл веб хуудас дээр байрласан байх ёстой.

- Баталгаажилтгүй оролцогч этгээд (тухайлбал, чөлөөлөгдсөн брэнд)-ийн нэрийн өмнөөс тухайн бүтээгдэхүүн дээр 'SFA Certified' мэдэгдэл (ж.нь, шошго) гаргасан тохиолдолд тус бүтээгдэхүүнд мэдэгдэл гаргасан оролцогч этгээдийн Хамрах хүрээний гэрчилгээг үндэслэнэ. ТҮБ нь тухайн чөлөөлөгдсөн брэндтэй шууд холбогдон ажиллаж болно.

2.11.10 Тухайн оролцогч этгээд нь өөрөө 'SFA Certified' байснаараа өөрийн 'SFA Certified' бус бүтээгдэхүүнийг 'SFA Certified' бүтээгдэхүүн гэх ойлголт төрүүлэхүйц Ерөнхий Мэдэгдэл гаргахыг **хориглоно**.

- Тодруулбал 'SFA Certified' лого нь бүгд 'SFA Certified' бус бүтээгдэхүүнүүдтэй нэг дор ашиглагдаж болохгүй. Жишээ нь, сурталчилж буй бүх бүтээгдэхүүн нь 'SFA Certified' биш бол каталогийн урд нүүр эсвэл хүрээ орчимд 'SFA Certified' лого байж болохгүй, мөн 'SFA Certified' бус бүтээгдэхүүнтэй нэг вэб хуудсан дээр лого байрлуулахыг хориглоно. Оролцогч этгээд нь өөрийн вэбсайт дээр 'SFA Certified' гэдгээ ерөнхий байдлаар харуулсан нэг хуудас байрлуулж, 'SFA Certified' лого ашиглаж болно, гэхдээ дагалдах текстэд баталгаажсан гэдэг нь тэдний бүх бүтээгдэхүүн 'SFA Certified' гэсэн үг биш гэдгийг тодорхой заасан байх ёстой (хэрэв энэ нь нотлогдохуйц биш бол).

Хүснэгт 3: Урьдчилан бэлтгэсэн мэдэгдэлүүд. Ерөнхий мэдээлэл, бүтээгдэхүүний мэдэгдэл, болон шаардлага хангасан мэдэгдлийн тайлбаруудыг ТННЭ-ийн тайлбар толь бичигт тодорхойлсон.

Ерөнхий мэдэгдэл	"Бид баталгаажсан малчдаас эхлэн бүтээгдэхүүн хүртэлх нийлүүлэлтийн сүлжээнд мөшгөсөн, гарал үүсэл нь тодорхой 'SFA Certified' ноолуурыг авдаг."
	"Манай нэрийн бараануудад 'SFA Certified' ноолуураар хийгдсэн бүтээгдэхүүнүүд багтдаг."
	"[Компани/брэнд] нь хариуцлагатай худалдан авалт хийх үүргийнхээ хүрээнд 'SFA Certified' ноолуурыг худалдаж авдаг."
	"SFA Certified' ноолуурыг худалдан авсанаараа [компани/брэнд] нь малын тавлаг байдал, байгаль орчны зохистой дадлууд болон малчдын амьжиргааг дэмжих ТННЭ-ийн эрхэм зорилгыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлдэг."
	"Манай 'SFA Certified' ноолуур нь 'SFA Certified' малчдын байгууллага болон боловсруулах үйлдвэрүүдээс ирдэг."
Бүтээгдэхүүний мэдэгдэл	"Энэхүү бүтээгдэхүүн нь 100% 'SFA Certified' ноолуураас бүрдэнэ."
	"Энэхүү [хувцас/бүтээгдэхүүн]-д орсон бүх ноолуурыг ТННЭ-ийн баталгаажилтын хүрээнд малын тавлаг байдлын сайн туршлагын дагуу үйлдвэрлэв."
	"Манай бүх ноолуур нь SFA Certified."
	"Энэхүү [утас/даавуу/бүтээгдэхүүн] нь 100% 'SFA Certified' ноолуурын агууламжтай."
Шаардлага хангасан мэдэгдэл	"Энэхүү хувцасыг үйлдвэрлэхэд орсон баталгаажсан ноолуурыг малын тавлаг байдлыг сайжруулах зохистой дадалд тулгуурлан үйлдвэрлэсэн."
	"SFA Certified' ноолуур нь малын тавлаг байдлын тэргүүлэх стандартад нийцүүлж, малчдаас эхлэн эцсийн бүтээгдэхүүн хүртэлх шат дамжлага бүрд мөшгөсөн, нийгмийн хариуцлагатай дадлуудыг дэмжих байдлаар үйлдвэрлэгдсэн болно."

	“SFA Certified” ноолуурыг худалдаж авах нь ноолуурын ханган нийлүүлэлтийн сүлжээнд бодит, нээлттэй байдлыг бий болгох ТННЭ-ийн ажлыг дэмжиж буй хэрэг юм.
	“ТННЭ-ийн үйл ажиллагаа нь ямааны тавлаг байдал, бэлчээр хамгаалал болон малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.”
	“ТННЭ нь малын тавлаг байдлыг сайжруулахын тулд малчидтай хамтарч ажилладаг ба ноолуурыг эцсийн бүтээгдэхүүн болох хүртэл мөшгөдөг.”
	“Энэхүү бүтээгдэхүүнийг худалдан авснаар та хариуцлагатай ноолуурын худалдааг дэмжиж байна.”
	“ТННЭ-ийн Алсын хараа нь ноолуурын үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, малчдын баталгаат амьжиргааг дэмжсэн, мал амьтдын тав тухтай амьдрах орчныг хангахад оршдог.”



Нийтэлсэн:

ТННЭ

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://sustainablefibre.org> хаягаар зочилж эсвэл info@sustainablefibre.org руу и-мэйл илгээнэ үү.